| 9             | Тайлант үеийн үр дүн                            | 0                               | 0                     | 185,560,663.91    | 185,560,663.91                         |
| 10            | 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл             | 1,827,585,506.15                | 1,886,923,363.95      | 1,070,623,794.11  | 4,785,132,664.21                       |
| 11            | 2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл               | 1,827,585,506.15                | 1,886,923,363.95      | 1,070,623,794.11  | 4,785,132,664.21                       |
| 12            | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0                               | 0                     | 551,662.46        | 551,662.46                             |
| 13            | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 1,827,585,506.15                | 1,886,923,363.95      | 1,071,175,456.57  | 4,785,684,326.67                       |
| 14            | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0                               | -551,662.46           | 0                 | -551,662.46                            |
| 15            | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| 16            | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| 17            | Өмчид гарсан өөрчилөлт                          | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| 18            | Зарласан ногдол ашиг                            | 0                               | 0                     | 0                 | 0                                      |
| 19            | Тайлант үеийн үр дүн                            | 0                               | 0                     | 4,400,442,094.37  | 4,400,442,094.37                       |
| 20            | 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл             | 1,827,585,506.15                | 1,886,371,701.49      | 5,471,617,550.94  | 9,185,574,758.58                       |

**2.5. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код         | Үзүүлэлт  | Төлөвлөгөө              | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|---|-------------------------|-----------------------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                  | <b>2,803,362,500.00</b> | <b>2,702,720,468.07</b>     |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | <b>2,545,381,000.00</b> | <b>2,469,072,569.07</b>     |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | <b>2,488,026,300.00</b> | <b>2,412,560,369.07</b>     |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | <b>1,685,383,200.00</b> | <b>1,646,786,947.04</b>     |
| 210101      | Үндсэн цалин  | 1,274,036,700.00        | 1,223,321,260.04            |
| 210102      | Нэмэгдэл  | 236,120,500.00          | 240,025,428.00              |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 5,808,000.00            | 5,122,790.00                |
| 210104      | Урамшуулал  | 103,728,700.00          | 115,066,673.00              |
| 210105      | Гэрээт ажлын хөлс   | 65,689,300.00           | 63,250,796.00               |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | <b>227,680,900.00</b>   | <b>210,495,478.33</b>       |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 160,220,000.00          | 147,965,069.31              |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 16,865,200.00           | 15,986,909.97               |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 13,492,200.00           | 13,098,239.16               |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                      | 3,373,100.00            | 3,093,090.98                |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                     | 33,730,400.00           | 30,352,168.91               |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>          | <b>260,017,700.00</b>   | <b>257,058,849.70</b>       |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 14,929,000.00           | 12,201,146.70               |
| 210302      | Түлш, халаалт   | 244,190,700.00          | 244,408,323.00              |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 898,000.00              | 449,380.00                  |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                   | <b>81,493,500.00</b>    | <b>79,415,445.00</b>        |
| 210401      | Бичиг хэрэг   | 6,652,100.00            | 6,661,100.00                |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 45,799,400.00           | 44,680,725.00               |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 4,541,900.00            | 4,137,340.00                |
| 210404      | Ном, хэвлэл   | 869,400.00              | 766,400.00                  |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,033,000.00            | 5,652,580.00                |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 16,597,700.00           | 17,517,300.00               |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                   | <b>100,956,600.00</b>   | <b>94,073,275.00</b>        |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                           | 24,905,300.00           | 24,868,260.00               |
| 210502      | Хоол, хүнс  | 68,366,600.00           | 61,522,815.00               |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                               | 7,684,700.00            | 7,682,200.00                |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                  | <b>52,803,000.00</b>    | <b>51,738,000.00</b>        |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                   | 37,416,300.00           | 36,352,600.00               |
| 210602      | Тавилга   | 2,500,000.00            | 2,500,000.00                |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                              | 783,300.00              | 782,000.00                  |
| 210604      | Урсгал засвар   | 12,103,400.00           | 12,103,400.00               |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                             | <b>6,939,200.00</b>     | <b>5,315,000.00</b>         |

|             |  |                         |                         |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 210702      | Дотоод албан томилолт  | 6,939,200.00            | 5,315,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>8,411,200.00</b>     | <b>7,153,924.00</b>     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,067,400.00            | 2,549,000.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,886,400.00            | 1,627,200.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 447,400.00              | 238,150.00              |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 268,700.00              | 147,474.00              |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 176,000.00              | 76,800.00               |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 2,237,900.00            | 2,187,900.00            |
| 210807      | Газрын төлбөр  | 327,400.00              | 327,400.00              |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>64,341,000.00</b>    | <b>60,523,450.00</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 51,610,800.00           | 49,717,250.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 12,730,200.00           | 10,806,200.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>57,354,700.00</b>    | <b>56,512,200.00</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>57,354,700.00</b>    | <b>56,512,200.00</b>    |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 29,951,100.00           | 29,158,600.00           |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 23,978,000.00           | 23,978,000.00           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 3,425,600.00            | 3,375,600.00            |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>137,981,500.00</b>   | <b>127,647,899.00</b>   |
| 223001      | Бусад хөрөнгө  | 137,981,500.00          | 127,647,899.00          |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>                    | <b>120,000,000.00</b>   | <b>106,000,000.00</b>   |
| 230001      | Эргэж төлөгдөх зээл  | 120,000,000.00          | 106,000,000.00          |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>2,803,362,500.00</b> | <b>2,681,763,090.43</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>1,828,653,400.00</b> | <b>1,783,483,885.22</b> |
| 310003      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                             | 1,702,908,300.00        | 1,657,738,786.22        |
| 310004      | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих                      | 125,745,100.00          | 125,745,099.00          |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>813,717,800.00</b>   | <b>789,895,555.43</b>   |
| 320001      | Орон нутгийн төсвөөс   | 813,717,800.00          | 789,895,555.43          |
| <b>33</b>   | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                  | <b>25,979,800.00</b>    | <b>23,787,925.00</b>    |
| 330002      | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                            | 25,979,800.00           | 23,787,925.00           |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | <b>135,011,500.00</b>   | <b>84,595,724.78</b>    |
| 350001      | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 52,000,000.00           | 84,595,724.78           |
| 350003      | Урьд оны үлдэгдлээс санхүүжих  | 83,011,500.00           | 0                       |
| <b>4</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              | <b>0</b>                | <b>87,180,358.55</b>    |

|            |   |            |               |
|------------|---|------------|---------------|
| 5          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл             | 0          | 66,222,980.91 |
| <b>6</b>   | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                       | <b>944</b> | <b>944</b>    |
| <b>61</b>  | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                       | <b>6</b>   | <b>6</b>      |
| 610001     | Төсвийн байгууллага   | 6          | 6             |
| <b>62</b>  | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                       | <b>137</b> | <b>137</b>    |
| 620001     | Удирдах ажилтан   | 12         | 12            |
| 620002     | Гүйцэтгэх ажилтан   | 86         | 86            |
| 620003     | Үйлчлэх ажилтан   | 27         | 27            |
| 620004     | Гэрээт ажилтан  | 12         | 12            |
| <b>63</b>  | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>                     | <b>664</b> | <b>664</b>    |
| <b>630</b> | <b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>              | <b>543</b> | <b>543</b>    |
| 630001     | Төрийн өмчит ЕБС  | 543        | 543           |
| <b>631</b> | <b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>               | <b>121</b> | <b>121</b>    |
| 631001     | Төрийн өмчит СӨБ байгууллага                                  | 121        | 121           |
| <b>65</b>  | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                    | <b>137</b> | <b>137</b>    |
| 650001     | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                            | 10         | 10            |
| 650004     | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)           | 57         | 57            |
| 650006     | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4          | 4             |
| 650008     | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 18         | 18            |
| 650009     | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                    | 33         | 33            |
| 650010     | Гэрээт ажилтан  | 8          | 8             |
| 650011     | Улс төрийн албан хаагч (УТ)                                   | 7          | 7             |

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Код         | Үзүүлэлт  | ТЗ цэвэр дүн / төгрөгөөр / |
|-------------|---|----------------------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | <b>269,312,657.00</b>      |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | <b>211,367,657.00</b>      |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | <b>175,241,557.00</b>      |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | <b>46,541,000.00</b>       |
| 210101      | Үндсэн цалин  | 46,541,000.00              |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | <b>4,500,000.00</b>        |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                    | 4,500,000.00               |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | <b>510,000.00</b>          |
| 210302      | Түлш, халаалт   | 510,000.00                 |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>               | <b>22,616,034.00</b>       |
| 210401      | Бичиг хэрэг   | 2,622,149.00               |
| 210402      | Тээвэр, шатахуун                                      | 12,091,885.00              |

|             |   |                       |
|-------------|---|-----------------------|
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 312,000.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал   | 2,210,000.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 5,380,000.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>71,429,480.00</b>  |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл   | 57,854,180.00         |
| 210502      | Хоол, хүнс  | 7,975,300.00          |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 5,600,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>27,564,500.00</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 11,050,000.00         |
| 210602      | Тавилга   | 9,579,400.00          |
| 210604      | Урсгал засвар   | 6,935,100.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | <b>452,000.00</b>     |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 452,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>1,628,543.00</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 324,043.00            |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 1,304,500.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>36,126,100.00</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>34,310,000.00</b>  |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 34,310,000.00         |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>1,816,100.00</b>   |
| 213405      | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг           | 1,816,100.00          |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>57,945,000.00</b>  |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>  | <b>57,945,000.00</b>  |
| 223001      | Бусад хөрөнгө   | 57,945,000.00         |
| <b>I</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>270,266,907.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>270,266,907.00</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 1,500,000.00          |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,610,000.00          |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 257,767,129.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 4,389,778.00          |
| <b>III</b>  | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>   | <b>954,250.00</b>     |
| 10          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | 954,250.00            |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт**

Хяргас сумын Засаг даргын эрхэм зорилго нь “Орон нутагт төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэн хууль дээдэлсэн чанартай үйлчилгээг иргэд олон нийтэд хүргэж сумын хөгжлийн төлөө ямагт манлайлан ажиллахад оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Бодлогын баримт бичгийг төлөвлөх боловсруулах хэрэгжүүлэх.
- Байгууллагын гадаад дотоод орчинд дүн шинжилгээ хийж стратегийг боловсруулан мөрдөх.
- Хүний нөөцийн менежментийг сайжруулж мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангах.
- Ажиллагсдын ажиллах орчин нийгмийн баталгаа хангах, сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Хяргас сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар 31.4 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,928.1 сая төгрөгийн 1 хувь буюу 39.2 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 34.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Хяргас сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,391.3 сая төгрөг буюу 104.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт       |
|---|----------------|-----------------|----------------|
| Б   | 1              | 2               | 3=2-1          |
| Мөнгөн хөрөнгө                                    | 117.0          | 171.2           | 54.2           |
| Авлага  | 204.3          | 302.7           | 98.4           |
| Бараа материал                                    | 413.1          | 395.7           | -17.3          |
| Үндсэн хөрөнгө                                    | 4,062.8        | 8,318.8         | 4,256.0        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>4,797.3</b> | <b>9,188.6</b>  | <b>4,391.3</b> |
| Өр төлбөр   | 12.1           | 3.0             | -9.1           |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 4,785.1        | 9,185.6         | 4,400.5        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>4,797.3</b> | <b>9,188.6</b>  | <b>4,391.3</b> |

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 117.0 сая, эцсийн үлдэгдэл 171.2 сая төгрөг болж, 54.2 сая төгрөгөөр өссөн нь Орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 204.3 сая, эцсийн үлдэгдэл 302.7 сая төгрөг болж, 98.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн даатгалын сан, сум хөгжүүлэх сангийн авлага үүссэнтэй холбоотой байна.

### 3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын дансны үлдэгдэл 395.7 сая төгрөг болж 17.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь бичиг хэргийн материал, бусад хангамжийн материал зарцуулсантай холбоотой үүссэн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс 8,318.7 сая төгрөг болж 4,256.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 50.8 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 137.3 сая, улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар авсан 4,500.2 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 88.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 98.3 сая, акталсан 124.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

### Аудитын илрүүлэлт:

#### Хяргас сумын Засаг даргын тамгын газар:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 544 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/159 дугаар тогтоолыг тус тус зөрчин Хяргас сумын ЗДТГ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4,283.9 сая төгрөгийн Хөв цөөрмийг данс бүртгэлд тусгаагүй байсныг данс бүртгэлд тусгуулан залруулсан.

2. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/26 тоот тогтоолоор Хяргас сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 31.0 сая төгрөгийн автомашиныг актлах шийдвэр гарсныг зөрчин данс бүртгэлээс хасаагүй байсныг залруулсан.

#### **Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, гэсэн заалтыг тус тус зөрчин үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 12.3 сая төгрөгөөр илүү, үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг 12.5 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байсныг залруулсан.

#### **3.5.5 Өр төлбөр**

Өр төлбөрийн данс 3.0 сая төгрөг болж 9.1 сая төгрөгөөр буурсан нь урьд оны өглөг буурсантай холбоотой байна.

#### **3.5.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,185.5 сая төгрөг болж 4,400.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 4,561.0 сая төгрөгөөр буюу 115.1 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 361.3 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна.

#### **3.5.7 Орлогын данс**

Тайлант онд татварын орлого 181.9 сая, татварын бус орлого 86.0 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,642.4 сая, нийт 3,910.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

#### **3.5.8 Зардлын данс**

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 8.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

#### **Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дахь хэсэгт тусгагдсан зардлыг санхүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.8 сая төгрөгийн бензин шатахууны зарцуулалтын тайланд замын хуудас хөтлөөгүйд зөвлөмж өгсөн.

#### **Хяргас сумын Эрүүл мэндийн газар:**

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэж заасныг зөрчин даатгуулагчаас төлөх 0.8 сая төгрөг, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал,

урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэж заасныг зөрчин олгосон цалингаас 0.6 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар тооцоогүй байсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчин 4.6 сая төгрөгийн 1890 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсанд албан шаардлага өгсөн.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хяргас сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/04 дүгээр тогтоолоор 2,716.0 сая төгрөгөөр баталж 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 4/01 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 87.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,803.4 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,803.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1,828.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 813.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 25.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 135.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,828.7 сая, орон нутгийн төсвөөс 813.8 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 23.7 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 84.6 сая, нийт 2,750.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,702.7 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 45.2 сая, орон нутгийн төсөвт 27.1 сая, нийт 72.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,702.7 сая төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь зардлыг 72.3 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хяргас сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 04/01 дүгээр тогтоолд зааснаар Хяргас сумын Засаг дарга тайлант онд 106.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 183.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 172.2 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 257.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.4 сая, хандив тусламж 8.1 сая нийт 270.2 сая төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн 269.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Хяргас сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 135, байршуулах хугацаа хоцроосон 21, байршуулах хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 68.0 сая төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12 Аудитын явцад хэрэгжүүлсэн ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Хяргас сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 тусгай санг түүврээр хамрагдсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 5 санал дүгнэлт, “Хязгаарлалтай” 1 санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 4,347.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,339.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.6 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д        | Аудитад хамрагдсан байгууллагын нэр       | Нийт алдаа, зөрчлийн |                | Үүнээс    |                |               |            |                 |            |          |            |
|------------|---|----------------------|----------------|-----------|----------------|---------------|------------|-----------------|------------|----------|------------|
|            |   |                      |                | Залруулга |                | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |            | Зөвлөмж  |            |
|            |   | Тоо                  | Дүн            | Тоо       | Дүн            | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн        | Тоо      | Дүн        |
| 1          | Хяргас сумын Засаг даргын тамгын газар    | 2                    | 4,314.9        | 2         | 4,314.9        |               |            |                 |            |          |            |
| 2          | Хяргас сумын Эрүүл мэндийн төв            | 2                    | 6.2            |           |                | 1             | 1.6        | 1               | 4.6        |          |            |
| 3          | Хяргас сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 2                    | 26.7           | 1         | 24.9           |               |            |                 |            | 1        | 1.8        |
| <b>ДҮН</b> |   | <b>6</b>             | <b>4,347.8</b> | <b>3</b>  | <b>4,339.8</b> | <b>1</b>      | <b>1.6</b> | <b>1</b>        | <b>4.6</b> | <b>1</b> | <b>1.8</b> |

#### 4. Аудитын илрүүлэлт

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

| №           | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |            | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|-------------|-------------------------------------|----------------------|------------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|             |                                     |                      |            | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|             |                                     | Тоо                  | Дүн        | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1           | Хяргас сумын Засаг дарга            | 0                    | 0.0        |           |     |               |     |                 |     |         |     |
| <b>НИЙТ</b> |                                     | <b>0</b>             | <b>0.0</b> |           |     |               |     |                 |     |         |     |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

М.БАТСУУРЫ/  
/М.БАТ-АМГАЛАН/  
/Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 03 сарын 25-ны өдөр